

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2023/04/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2023 он

Цахим хуудас: www.open.audit.mn

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл

Утас: 99040705

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.04.05 № 335
танай _____ -ны № _____ -т

Г **Өөрчлөлтгүй дүгнэлт** Г

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ЭНХТӨР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 524,905.5 мянган төгрөг, авлага 179,219.9 мянган төгрөг, урьдчилгаа 328,976.6 мянган төгрөг, бараа материал 113,886.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,194,076.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 4,251,064.3 мянган төгрөг байна.

Тайлант онд 649,608,6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 295,602.2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, төсвийн байгууллагуудад 1,005,808.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Оны эцэст төсөвт байгууллагуудын зарцуулагдаагүй үлдэгдэл 141,786.7 мянган төгрөгийг сумын ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 14284.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 17,214.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 470.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Дархан сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхдээ харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг 535,738.4 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн алдаа илэрч санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлээ.

2023

232330454

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн хамт бэлтгэх, нэгтгэгдэж буй байгууллагуудын санхүүгийн тайланг и тайланд үнэн зөв илгээсэн эсэхэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,243,420.2	1,056,988.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	829,236.3	524,905.5
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	178,941.6	179,219.9
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	27,024.3	238,976.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	208,218.0	113,886.4
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,596,765.5	3,194,076.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,596,765.5	3,194,076.0
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		4,542,002.0	3,165,371.0
39300	Биет бус хөрөнгө	13	54,763.5	28,705.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,840,185.8	4,251,064.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		90.0	1,197,842.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	90.0	1,197,842.3
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	90.0	2,320.0
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	1,195,522.4
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,840,095.8	3,053,222.0
51	Засгийн газрын хувь оролцоо		5,840,095.8	3,053,222.0
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,828,941.0	457,233.7
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		0.0	0.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		0.0	457,233.7
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/		0.0	0.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/		0.0	0.0
51104	Халаасны хувьцаа /ТӨҮГ/		0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/		0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн		-747,347.5	2,541,494.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,758,502.3	54,493.8
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0.0	0.0
51600	Нөөцийн сан		0.0	0.0
52	Хяналтын бус хувь оролцоо		0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,840,185.8	4,251,064.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,043,792.9	2,099,115.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		272,052.9	490,427.6
110	Орлогын албан татвар		93,501.9	217,963.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		93,501.9	217,963.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар		0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар		0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого		0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар		80,797.0	100,589.7
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар		0.0	0.0
115	Онцгой албан татвар		0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого		0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого		0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		97,754.0	171,874.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	546,415.6	1,143,100.0
120	Нийтлэг татварын бус орлого		546,415.6	1,143,100.0
121	Хөрөнгийн орлого		0.0	0.0
122	Тусламжийн орлого		0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		0.0	0.0
124	Зээлийн орлого		0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,225,324.4	465,588.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,375,761.7	1,200,864.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,375,761.7	1,200,864.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,235,639.7	1,184,356.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,027,643.2	277,180.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		149,140.3	34,715.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		213,466.1	230,791.2
2104	Хангамж, бараа материалын зардал		66,294.3	26,727.6
2105	Нормативт зардал		70,735.5	551.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		47,927.6	21,871.2
2107	Томилолт, зочны зардал		10,162.0	12,537.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		283,344.7	312,769.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		366,926.0	267,212.9
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		140,122.0	16,507.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		668,031.2	898,251.2
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		978.2	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		421,393.6	2,241,770.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		247,615.9	-1,343,519.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,209,025.3	0.0	4,209,025.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	28,553.9	0.0	28,553.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,237,579.2	0.0	4,237,579.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-6,112.4	0.0	-6,112.4
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,355,889.6	0.0	1,355,889.6
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	5,123.5	0.0	5,123.5
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	247,615.9	0.0	247,615.9
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,840,095.8	0.0	5,840,095.8
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,840,095.8	0.0	5,840,095.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-141,791.7	0.0	-141,791.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,698,304.1	0.0	5,698,304.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	-1,301,562.6	0.0	-1,301,562.6
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	-1,343,519.5	0.0	-1,343,519.5
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,053,222.0	0.0	3,053,222.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,904,925.6	1,525,145.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	272,052.9	490,427.6
110	Орлогын албан татвар	93,501.9	217,963.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	93,501.9	217,963.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	0.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	0.0
1103	ААН-ын орлогын албан татвар	0.0	0.0
1104	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	0.0
113	Хөрөнгийн албан татвар	80,797.0	100,589.7
114	Нэмэгдсэн өртгийн албан татвар	0.0	0.0
115	Онцгой албан татвар	0.0	0.0
116	Тусгай зориулалтын орлого	0.0	0.0
117	Гадаад үйл ажиллагааны орлого	0.0	0.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	97,754.0	171,874.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	30,697.1	26,056.6
1181	Газрын төлбөр	66,506.9	145,598.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	550.0	220.0
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	432,697.0	569,130.2
120	Нийтлэг татварын бус орлого	432,697.0	569,130.2
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,200,175.7	465,588.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,044,726.3	1,141,188.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,044,726.3	1,141,188.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,904,802.2	1,059,194.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,121,007.6	371,966.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,633.4	60,273.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,690.1	229,191.3
2104	Хангамж, бараа материалын зардал	62,761.8	163,101.2
2105	Нормативт зардал	69,748.2	551.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,004.6	15,193.2
2107	Томилолт, зочны зардал	10,162.0	12,537.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	161,509.5	117,368.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,285.0	89,011.6
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,924.1	81,993.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	860,199.3	383,957.7
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	358,018.3	598,288.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	358,018.3	598,288.5
2200	Дотоод эх үүсвэрээр	358,018.3	598,288.5
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-358,018.3	-598,288.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-17,000.0	-90,000.0
14	Бусад эх үүсвэр	0.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	17,000.0	90,000.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	485,181.0	-304,330.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	344,055.3	829,236.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	829,236.3	524,905.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,945,992.20	1,436,990.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	936,979.10	781,344.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	925,443.80	769,816.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,097.80	277,111.87
210101	Үндсэн цалин	206,859.10	202,280.80
210102	Нэмэгдэл	70,713.90	50,924.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,432.00	2,750.00
210104	Урамшуулал	10,042.40	9,337.80
210105	Гэрээт ажлын хөлс	19,050.40	11,819.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,757.20	34,784.00
210201	Тэтгэврийн даатгал	26,354.10	23,922.55
210202	Тэтгэмжийн даатгал	3,097.20	2,787.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,484.10	2,225.29
210204	Ажилгүйдлийн даатгал	620.10	521.12
210205	Эрүүл мэндийн даатгал	6,201.70	5,327.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	248,013.80	228,953.60
210301	Гэрэл, цахилгаан	19,535.50	18,172.42
210302	Түлш, халаалт	224,094.30	207,609.18
210303	Цэвэр, бохир ус	4,384.00	3,172.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,342.30	24,309.94
210401	Бичиг хэрэг	3,581.20	3,142.48
210402	Тээвэр, шатахуун	16,838.40	16,726.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,498.00	3,017.31
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,424.70	1,424.15
2105	Нормативт зардал	615.30	551.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	615.30	551.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,933.50	17,390.91
210602	Тавилга	2,920.00	2,919.70
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000.00	967.00
210604	Урсгал засвар	14,013.50	13,504.21
2107	Томилолт, зочны зардал	13,382.80	12,308.00
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	13,382.80	12,308.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,230.50	142,143.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	229,012.50	141,445.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	511.90	510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	261.00	68.51
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89.50	88.00
210807	Газрын төлбөр	31.60	31.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,070.60	32,262.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,572.00	30,119.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,498.60	2,143.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,535.30	11,528.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,535.30	11,528.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	8,368.70	8,368.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,166.60	3,160.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	715,001.80	565,645.44
223001	Бусад хөрөнгө	715,001.80	565,645.44
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	294,011.30	90,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	294,011.30	90,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,945,992.20	1,086,070.96
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,175,735.20	1,020,511.22
320001	Орон нутгийн төсвөөс	1,020,033.40	864,809.42
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	155,701.80	155,701.80
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	770,257.00	65,559.75
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,792.90	63,949.75
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	900.00	1,610.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	654,564.10	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	659,518.37
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	308,599.08

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,685.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,685.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,243.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237.73
210301	Гэрэл, цахилгаан	237.73
2104	Хангамж, бараа материалын зардал	1,710.20
210401	Бичиг хэрэг	91.30
210402	Тээвэр, шатахуун	1,492.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120.00
210404	Ном, хэвлэл	6.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	562.00
210604	Урсгал засвар	562.00
2107	Томилолт, зочны зардал	229.00
210702	Дотоод албан томилолт	229.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,790.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,790.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,714.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,075.33
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	639.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,441.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,970.94
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,970.94
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	470.79
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	470.79
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,284.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,284.10
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,036.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,247.50
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-3,401.48
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,401.48

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Дархан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 535,738.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулав.

3.1.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга:

ЖДБДС:

- Хаалтын тайлан хийх хүртэл орсон орлого 70.0 мянган төгрөгийг орлого үр тайланд тусгаагүй;
- Өмчийн өөрчлөлтийн тайланд НББ-ийн өөрчлөлт дансыг 70,913.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн
- Орлого үр дүнгийн тайланд тайлант оны үр дүнг 109,655.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн

Тохижилт үйлчилгээний газар:

- Орлого үр дүнгийн тайланд орлого, зардлыг 106,040.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн
- Мөнгөн гүйлгээний тайланд орлого дансны харилцааг алдаатай хийж 248,867.4 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг бусад орлого дансанд бүртгэсэн

ЭМТ:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлийг 192.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;

3.2 Дархан сумын харьяа улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын дүн, илэрсэн алдаа зөрчил.

Дархан сумын засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн байгууллага 2, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 2, төрийн сан 1, орон нутгийн тусгай сан 4, улсын төсвийн байгууллага 4, нийт 13 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Үүнээс 5 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган, 3 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж аудитад хамруулсан. ЖДБДС, ЭЭС болон улсын төсөвт шилжиж буй ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ-ийн хаалтын балансыг Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хүрээнд шалгасан болно.

ЗДТГ-ын санхүүгийн тайланд Төрийн аудитын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “Өндөрхаан итгэл аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Дархан сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 270,461.4 мянган төгрөгийн 8 алдаа, 46,309.9 мянган төгрөгийн 16 зөрчил, санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд шалгасан шилэн дансны тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 870,059.0 мянган төгрөгийн 7 зөрчил, нийт 721,950.8 мянган төгрөгийн 18 алдаа зөрчил илэрсэн байна.

Үүнээс 270,461.4 мянган төгрөгийн 8 алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 150,296.9 мянган төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өгч, 17,684.8 мянган төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 748,387.2 мянган төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Алдаа зөрчлийг байгууллагаар нь авч үзвэл:

Засаг даргын тамгын газар:

- “Уран тод цэг” ХХК-д их засварын ажлын зураг төсөв гаргуулах 6,000.0 мянган төгрөг, “Хайталмегават” ХХК-д засмал замын зураг төсвийг гаргуулах 6,000.0 сая төгрөг, “Вектор мел” ХХК-д нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийлгэх 19,000.0 мянган төгрөг, “Дөрвөн талст” ХХК-д хилийн цэс тогтоох 17,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй зардалд хаасан;
- Ахмадын өргөөг сантехникийн ажил хийж дулаанд холбоход 10,366.0 мянган төгрөг, хашаа хийхэд 4,767.4 мянган төгрөг зарцуулсан боловч хөрөнгийг бүртгэлд аваагүй зардалд хаасан;

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 63,133.4 мянган төгрөгийн залруулга хийв.

- Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч 1,500.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Албан ажлаар ирсэн албан тушаалтуудын хоолны зардал 2,230.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөс төлж төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ хэсэгт 17,520.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ хэсэгт 9,328.3 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зэрэг нийт 26,849.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн дахин давтахгүй байх зөвлөмж өгөв.

Дархан тохижилт үйлчилгээний газар:

- НӨАТ-ын өглөгийг 1,637.4 мянган төгрөгөөр дутуу тусгасан, ААНОАТ-ын өглөг 647.9 мянган төгрөгийг санхүүгийн тайландаа тусгаагүй орхигдуулсан;
- Дархан учир ХХК-аас авах 1,877.7 мянган төгрөгийн авлага, Алтан богд хайрхан ХХК-аас авах 529.8 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд дэлгэрэнгүй бүртгэлээс 2,592.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн тайланд 3,000.0 мянган төгрөгийн программ хангамжийг бараа материалд бүртгэсэн;

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд нийт 10,01.8 мянган төгрөгийн залруулга хийв.

- Цалингийн урьдчилгаа 350.0 мянган төгрөгийг олгосон боловч суутган тооцоогүй зардалд хаасан;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 92,652.1 мянган төгрөгийн 11 гүйлгээг, зарлагын 10,352.7 мянган төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй, тухайн сарын орлого зарлагыг мэдээлээгүй өссөн дүнгээр мэдээлсэн зэрэг нийт 103,011.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

Орон нутгийн хөгжлийн сан:

- Жил дамжин хийгдэх дуусаагүй ажлын тайлант онд олгосон 190,976.6 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг санхүүгийн тайландаа урьдчилж гарсан зардлаар бүтгээгүй;

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

Байгаль хамгаалах сан:

- Байгаль хамгаалах сангийн үлдэгдэл 14,059.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Хоршоо хөгжүүлэх сан:

- Тайлант оны хүүгийн орлогыг 4,836.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

Эрүүл мэндийн төв:

- Тайлант онд албан хаагчдад тушаал шийдвэргүй 500.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Жилийн эцэст эм боох материал, хүнсний материалын 1,763.8 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж, тооцоо хийж баталгаажуулаагүй;
- Тайлант хугацаанд ажиллагсад олгосон цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тайлагнахдаа 1,589.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 34,117.9 мянган төгрөгийн 3 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 6 тушаал шийдвэр байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Анхан шатны баримтын бүрдлийг шалгахад төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 6,497.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Ерөнхий боловсролын сургууль:

- Хоол хүнсний нэр төрлийн тайлангаар анхан шатны баримтын бүрдэлгүй зөрүүтэй тайлагнаж, хоолны зардлыг 780.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Тогоочийн цалинг давхардуулж, мөн дутуу ажилласан хоногт 289.6 мянган төгрөгийн цалинг илүү олгосон;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Цэвэр бохир усны тогтмол зардлаас 1,352.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад 28,020.8 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 4 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс

дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 692,128.3 мянган төгрөгийн мөнгөн 21 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Анхан шатны баримтын бүрдлийг шалгахад төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 1,764.7 мянган төгрөгөөр дутуу байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Хүүхдийн цэцэрлэг:

- Ээлжийн амралтын цалинг 1 ажилтанд 204.8 мянган төгрөгөөр илүү олгосон;

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Эрхлэгчийн шийдвэргүйгээр 9,126.9 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон;
- Тайлант оны эцэст 890.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, тооцоо бодож баталгаажуулаагүй;
- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,189.4 мянган төгрөгийн 1 мөнгөн гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 3 тушаал шийдвэр байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

- Анхан шатны баримтын бүрдлийг шалгахад төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 3,411.6 мянган төгрөгөөр дутуу байна;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Соёлын төв:

- Программ хангамж авах урьдчилгаа 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгө нь ашиглалтад ороогүй, хүлээж авах шийдвэр гараагүй байхад хөрөнгөөр бүртгэсэн

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийв.

- Тайлант онд аж ахуйн материал их хэмжээгээр бэлтгэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй;
- Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5,200.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	535,738.4			1	535,738.4	1	535,738.4	-	-	-	-
ЗДТГ	1	63,133.4			1	63,133.4	1	63,133.4				
Тохижилт үйлчилгээний газар	4	10,014.8	2.0	4,422.8	2.0	5,592.0	4	10,014.8				
ОНХС	1	190,976.6			1	190,976.6	1	190,976.6	-			
ХХС	1	4,836.6			1	4,836.6	1	4,836.6	-	-	-	-
Дүн	8	804,699.8	2	4,422.8	6	800,277.0	8	804,699.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
ЗДТГ	2	3,730.0	1	1,500.0	1	2,230.0						
Тохижилт үйлчилгээний газар	1	350.0	1	350.0								
БХС	1	14,059.5	1	14,059.5	-	-	-	-	-	-		
Дүн	4	18,139.5	3	15,909.5	1	2,230.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ИТХ	1	26,849.2								1	26,849.2	
Тохижилт үйлчилгээний газар	1	103,011.8								1	103,011.8	
Дүн	2	129,861.0	0	0	0	0	0	0	0	2	129,861.0	

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	4	2		4			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ОНТС	4		4					
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
6	ОНӨААН	2	1	1		1			
	НИЙТ	13	6	7		6			